



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 5/23

Чингис хот

Ажилд томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 24.1 дэхь заалт, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай 275 дугаар тогтоолын хавсралт, Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авилгатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, удирдах ажилтны тусгай шалгалтанд тэнцсэн Д.Цогт-Эрдэнийг 2021 оны 11 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын даргаар томилсугай.

2. Цогт-Эрдэнийн үндсэн цалинг ТҮСУ-6-3 шатлал 932,617 (есөн зуун гучин хоёр мянга зургаан зуун арван долоон мянган) төгрөг төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 20 хувиар тогтоож олгохыг Хан Хэнтий чуулгын нягтлан бодогч (С.Болортуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахатан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012457